

GEDORE

НАСНЫ БАГАЖ



**МУШГИХ МОМЕНТЫН ШИЙДЭЛҮҮД
0,04 – 54.000 Нм**

БҮХ ХҮЧИЙГ НЭГ ДОРООС АВАХ БОЛОМЖ

WWW.BAGAJ.MN

Аюулгүй ажиллагаа, өндөр нарийвчлал

МУШГИХ МОМЕНТЫН ЧАНГАЛГААНЫ ТЕХНОЛОГИ

Аж үйлдвэр, засвар үйлчилгээ, угсралтын ажилд эд ангиудын холболтод тавигдах техникийн шаардлага улам бүр нарийссаар байна. Үүнд ашиглагдах материал, ажлын орчин, хэрэглээний зориулалт, буцаж мөшгөх боломж (traceability), процессын найдвартай байдал зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Ийм нөхцөлд зөв багаж сонгох нь зөвхөн угсралтын асуудал биш бөгөөд үйлдвэрлэлийн чанар, аюулгүй ажиллагаа, ашиглалтын найдвартай байдлыг тодорхойлох чухал хүчин зүйл болдог. Мушгих моментыг багаж нь энгийн болон нарийн төвөгтэй бүх төрлийн чангалгаанд технологийн дагуу тогтвортой урьдчилсан ачаалал үүсгэх боломжийг олгодог. Ингэснээр боолтны холболтыг найдвартай чангалах, шаардлагатай үед гэмтээлгүйгээр суллах нөхцөл бүрдэнэ.

Зөв мушгих моментыг технологи ашигласнаар:

- холболтын найдвартай байдал сайжрах
- материалын гэмтэл буурах
- эд ангийн ашиглалтын хугацаа уртсах
- үйлдвэрлэлийн зардал буурах
- процессын тогтвортой байдал хангагдах давуу талтай.

Өндөр нарийвчлалтай мушгих моментыг багажууд нь үйлдвэрлэл, засвар үйлчилгээ болон чанарын хяналтын орчинд техникийн стандарт, дүрэм журмын шаардлагыг хангах үндсэн хэрэгсэл болдог.



ГЕДОРЕ БРЭНД

0.04–54,000 НМ ХҮРТЭЛХ МУШГИХ МОМЕНТЫН ЧАНГАЛГААНЫ НАРИЙВЧЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

GEDORE нь 0.04–54,000 Нм хүртэлх бүх төрлийн мушгих моментыг хэрэглээнд зориулсан нарийвчлалтай чангалгааны шийдлийг санал болгодог. Бид дижитал болон механик ажиллагаатай мушгих моментыг багаж, хэмжилтийн систем, инженерийн зөвлөгөө, сервис үйлчилгээний иж бүрэн шийдлийг хэрэглэгчдэд хүргэдэг.

GEDORE нь 100 гаруй жилийн туршлагатай мэргэжлийн багаж болон хэмжилтийн төхөөрөмж үйлдвэрлэгч юм. Манай шийдлүүд нь үйлдвэрлэлийн чангалгааны процессыг өндөр нарийвчлалтай гүйцэтгэх, хэмжилтийн үр дүнг бүртгэх, процессын найдвартай ажиллагааг хангах зориулалттай.

GEDORE-ийн мушгих моментыг технологи нь:

- нарийвчлалтай чангалгаа
- аюулгүй ажиллагаа
- буцаж мөшгөх баримтжуулалт
- процессын найдвартай байдал
- үйлдвэрлэлийн хяналт

зэрэг шаардлагыг хангахад чиглэгддэг.

Мөн эталон төхөөрөмж, хэмжилт, шинжилгээ, тохируулга, баталгаажуулалт болон инженерийн зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг. GEDORE брэндийн албан ёсны дистрибьютер ЧПМ ХХК нь үйлдвэрлэлийн бүх төрлийн чангалгаанд тохирсон найдвартай инженерийн шийдлийг санал болгож байна.

APPLICATION CENTER TORQUE

Хэрэглэгчдийн тусгай шаардлагад илүү хурдан, оновчтой инженерийн шийдэл боловсруулах зорилгоор GEDORE компани 2021 онд "Application Center Torque" төвийг байгуулсан. Энэхүү төв нь мушгих моментын технологийн улам бүр нарийсч, төвөгтэй болж буй хэрэглээний шаардлагад төвлөрөн ажилладаг. Үүний хүрээнд боолтны холболт, чангалгааны процесс, үйлдвэрлэлийн орчны онцлогт тохирсон шийдлийг инженерийн түвшинд боловсруулж байна.

Ингэснээр хэрэглэгчид болон хамтран ажиллагч байгууллагууд:

- хөгжүүлэлтийн богино хугацаа
 - илүү оновчтой шийдэл
 - хэрэглээнд суурилсан инженерчлэл
 - шинэ технологийн давуу тал
 - процессын найдвартай ажиллагаа
- зэрэг олон давуу талыг хүртэх боломжтой болсон.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА ЯМАР Ч ЭРГЭЛЗЭЭГҮЙ

GEDORE нь 0.04–54,000 Нм хүртэлх мушгих моментын өргөн хүрээний багаж, системийн шийдлийг санал болгодог. Манай мушгих моментын багажууд нь үйлдвэрлэл, засвар үйлчилгээ, эрчим хүч, уул уурхай, дэд бүтэц зэрэг салбарын онцлог шаардлагад нийцүүлэн боловсруулагдсан аюулгүй, найдвартай инженерийн шийдэл юм. GEDORE-ийн үйлдвэрлэлийн стандарт нь олон улсын техникийн шаардлагад нийцэхээс гадна олон тохиолдолд түүнээс давсан нарийвчлал, найдвартай байдлыг хангадаг.

Манай багаж, төхөөрөмжүүд:

- өндөр нарийвчлалтай хэмжилт
- тогтвортой чангалгаа
- давтагдах үр дүн
- аюулгүй ажиллагаа
- урт хугацааны ашиглалт

зэргийг хангах зориулалттай бүтээгдсэн.

Өндөр нарийвчлал шаардсан чангалгааны ажилд хэмжилтийн тогтвортой байдал, процессын найдвартай ажиллагаа нь үйлдвэрлэлийн чанарын үндсэн үзүүлэлт болдог

ЗАРДЛЫГ ХЯНАЛТАНД БАЙЛГАНА

Үйлдвэрлэлийн орчинд боолтны холболтын зөв хэмжээс, зөв чангалгааны нөхцөлийг тодорхойлох нь маш чухал байдаг. Үүний тулд чангалгааны технологийн шинжилгээ хийж, тухайн хэрэглээнд тохирсон мушгих моментын шийдлийг зөв сонгох шаардлагатай. GEDORE-ийн дижитал мушгих моментын системүүд нь чангалгааны процессыг нарийвчлан хэмжих, шинжлэх, хянах боломжийг олгодог. Ингэснээр үйлдвэрлэлийн процессыг оновчтой зохион байгуулах, материал болон ашиглалтын зардлыг бууруулах нөхцөл бүрдэнэ. Холболтын төрөл, хэрэглээний онцлогоос хамааран зөв чангалгааны технологи ашигласнаар

- эд ангийн элэгдэл буурах
- материалын хэмнэлт бий болох
- дахин засварын ажил багасах
- үйлдвэрлэлийн зардал буурах
- процессын найдвартай байдал сайжрах давуу талтай.

GEDORE нь чангалгааны технологийн бүх үе шатанд инженерийн зөвлөгөө, хэмжилт, анализ болон процессын шийдлээр таны найдвартай түнш байх болно.

БАТАЛГААЖСАН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

GEDORE нь мушгих моментын багаж болон тестер төхөөрөмжүүдэд DIN EN ISO 6789-2:2017 стандартын дагуу тохируулга, баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг. Мөн хэрэглэгчийн техникийн шаардлага болон DIN, DAkkS, UKAS зэрэг олон улсын стандартын дагуу шалгалт, тохируулга, баталгаажуулалт хийж сертификат олгодог. Мушгих моментын багаж, хэмжилтийн төхөөрөмжийг тогтмол шалгаж, баталгаажуулах нь:

- хэмжилтийн буцаж мөшгөх боломжийг хангах
- хэмжилтийн тогтвортой байдлыг баталгаажуулах
- процессын найдвартай ажиллагааг сайжруулах
- чанарын шаардлагыг хангах чухал нөхцөл болдог.

GEDORE нь хэрэглэгчдэд өөрийн ашиглалтын нөхцөл, хяналтын мөчлөгт тохируулан багаж, төхөөрөмжөө тогтмол шалгаж, баталгаажуулж байхыг зөвлөдөг.

ЭХЭЛСЭН ЦАГААСАА ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭСЭН

TOOLS FOR LIFE

GEDORE нь 100 гаруй жилийн турш багаж, тоног төхөөрөмжийг урт хугацааны найдвартай ашиглалтыг үндсэн зарчим болгон хөгжүүлж ирсэн. Өндөр чанар, аюулгүй ажиллагаа, тогтвортой ашиглалт нь GEDORE брэндийн үнэт зүйлсийн нэг хэсэг юм. Иймээс манай мушгих моментын багажууд олон жилийн ашиглалтын дараа ч хэмжилтийн нарийвчлал, ажиллагааны найдвартай байдлаа хадгалсаар байдаг.

GEDORE-ийн бүтээгдэхүүний хөгжүүлэлт нь:

- урт хугацааны ашиглалт
- засвар үйлчилгээний боломж
- дахин ашиглалт
- нөөцийн хэмнэлт
- байгаль орчинд ээлтэй хэрэглээ гэсэн зарчимд тулгуурладаг.

Бид зөвхөн мушгих моментын багаж үйлдвэрлэдэггүй. Мөн бүтээгдэхүүний ашиглалтын бүх хугацаанд тохируулга, баталгаажуулалт, засвар үйлчилгээ үзүүлж, процессын найдвартай ажиллагааг дэмждэг.

TOOLS FOR LIFE философи нь чанар, тогтвортой хэрэглээ, инженерийн найдвартай байдлыг урт хугацаанд хадгалах GEDORE-ийн үндсэн үзэл баримтлал юм.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ПРОЦЕССИЙН ИНТЕГРАЦ

Манай мэргэшсэн мушгих моментын экспертүүд таны чангалгааны технологийн бүх үе шатанд инженерийн зөвлөгөө үзүүлэхэд бэлэн байна.

Үүнд:

- тохирох мушгих моментын багаж сонгох
- үйлдвэрлэлийн процесст интеграц хийх
- хэмжилтийн өгөгдөл боловсруулах
- процессын найдвартай ажиллагааг хангах
- чангалгааны технологийг оновчлох зэрэг багтана.

GEDORE нь 0.04–54,000 Нм хүртэлх мушгих моментын шийдлийг санал болгодог бөгөөд хэрэглээ бүрт тохирсон инженерийн шийдлийг боловсруулах боломжтой.

МУШГИХ МОМЕНТЫН ТЕХНОЛОГИЙН ИРЭЭДҮЙ

GEDORE нь дижитал болон электрон мушгих моментын шийдлүүдийг үйлдвэрлэлийн процесст нэвтрүүлж эхэлснээс хойш хэмжилтийн өгөгдөл, баримтжуулалт, анализын системийг тогтмол хөгжүүлж ирсэн. Бид хэрэглэгчдийнхээ үйлдвэрлэлийн онцлог, процессын шаардлагад нийцүүлэн өндөр хүчин чадалтай программ хангамж болон дижитал интеграцын шийдлийг ашиглан ажилладаг. Өсөн нэмэгдэж буй дижитал хэрэглээ болон үйлдвэрлэлийн шинэ шаардлагад нийцүүлэн бид мушгих моментын шийдэл, сервисийн үйлчилгээг хэрэглэгчидтэйгээ хамтран тасралтгүй хөгжүүлсээр байна.

Цаашид:

- үйлдвэрийн процессын дижитал хяналт
- хэмжилтийн өгөгдөл дамжуулалт
- виртуал орчны интеграци
- AI болон ухаалаг үүлэн систем
- баримтжуулалтын автомат шийдэл

зэрэг технологиуд нь мушгих моментын системийн салшгүй хэсэг болно.

GEDORE нь ирээдүйн дижитал үйлдвэрлэлийн орчинд тохирсон мушгих моментын инженерийн шийдлийг хөгжүүлсээр байна.

МЭДЛЭГТ СУУРИЛСАН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

GEDORE нь суурь ойлголтоос эхлээд нарийн төвөгтэй үйлдвэрлэлийн хэрэглээнд зориулсан мушгих моментын технологийн сургалтуудыг санал болгодог. Манай мэргэшсэн экспертүүд хэрэглэгчийн хэрэгцээ, үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн сургалтыг практик хэрэглээнд тулгуурлан зохион байгуулдаг. Сургалтын агуулгад:

- мушгих моментын суурь ойлголт
- чангалгааны технологи
- хэмжилтийн аргачлал
- процессын найдвартай байдал
- багажийн зөв хэрэглээ
- баримтжуулалт ба анализ зэрэг сэдвүүд багтдаг.

Бодит үйлдвэрлэлийн жишээ, практик хэрэглээнд суурилсан сургалтын аргачлал нь мушгих моментын технологийн ойлголтыг илүү хялбар, үр дүнтэй эзэмших боломжийг бүрдүүлдэг. GEDORE нь хэрэглэгчдийг зөвхөн багаж ашиглагч бус, чангалгааны технологийг ойлгодог мэргэжлийн хэрэглэгч болоход дэмжлэг үзүүлдэг.



БАГА хүчний мушгих моментын шийдэл




Электрон эд анги угсралт, анагаах ухаан, лаборатори болон өндөр нарийвчлал шаардсан үйлдвэрлэлийн орчинд жижиг, мэдрэмтгий эд ангийн холболтод маш бага мушгих момент ашиглагддаг. Ийм төрлийн холболтод тогтвортой, өндөр нарийвчлалтай чангалгаа хийх шаардлагатай байдаг. Ингэснээр эд ангид гэмтэл үүсгэхгүйгээр жигд, найдвартай холболт хийх боломж бүрдэнэ.

GEDORE нь 0.04–100 Нм хүртэлх бага мушгих моментын багаж, шийдлүүдийг санал болгодог.

Эдгээр багажууд нь:

- өндөр нарийвчлалтай угсралт
- цуврал үйлдвэрлэл
- мэдрэмтгий эд ангийн чангалгаа
- бага мушгих моментын хэрэглээ
- тогтвортой давтагдах чангалгаа зэрэг хэрэглээнд тохиромжтой.

GEDORE-ийн бага мушгих моментын багажууд нь үйлдвэрлэлийн процессын найдвартай ажиллагаа болон өндөр нарийвчлалтай угсралтын шаардлагыг хангахад зориулагдсан.



УР ЧАДВАРЫН НОТолГОО

TSN Slipper загвар нь "Slipper" технологид суурилсан ажиллагаатай бөгөөд тохируулсан мушгих моментын хэмжээнд хүрмэгц автоматаар сул эргэлтэд шилжинэ. Ингэснээр тохируулсан хэмжээнээс хэт чангалалт үүсэхээс сэргийлж, мэдрэмтгий эд анги болон бага мушгих момент шаардсан холболтод найдвартай хамгаалалт үзүүлдэг



ДУНД хүчний мушгих моменты шийдэл



GEDORE нь 10–3000 Нм хүртэлх мушгих моменты хэрэглээнд зориулсан багаж, системийн шийдлийг санал болгодог.

Эдгээр шийдэл нь стандарт металл хийцийн холболтоос эхлээд цуврал үйлдвэрлэл, дахин ашиглагдах холболт болон хэрэглэгчийн тусгай шаардлагад нийцсэн чангалгааны технологийг хамардаг.

Бид чангалгааны бүх үе шатанд:

- зөв мушгих момент сонгох
- аюулгүй чангалгаа хийх
- давтагдах нарийвчлал хангах
- процессын найдвартай ажиллагааг сайжруулах шийдлээр хэрэглэгчдээ дэмжин ажилладаг.

GEDORE нь энгийн мушгих моментын түлхүүрээс эхлээд хөнгөн хийцтэй DREMOMETER загвар хүртэл төрөл бүрийн шийдлийг санал болгодог. DREMOMETER загвар нь багажийн урт болон барих байрлалаас үл хамааран хэмжилтийн өндөр нарийвчлалыг хадгалдаг онцлогтой. Ингэснээр үйлдвэрлэлийн орчинд тогтвортой, найдвартай чангалгаа хийх боломж бүрддэг.



УР ЧАДВАРЫН НОТолгоо

GEDORE нь зах зээлд хөнгөн хийцтэй, уртаас үл хамаарах DREMOMETER загварын мушгих моментын түлхүүрийг санал болгодог.

Энэхүү технологи нь багажийн барих байрлал болон ажлын нөхцөлөөс үл хамааран хэмжилтийн өндөр нарийвчлалыг тогтвортой хадгалах боломжийг бүрдүүлдэг.

90 -
54.000

Нм

ИХ хүчний мушгих моменты шийдэл



GEDORE нь 90–54,000 Нм хүртэлх их хүчний мушгих моменты багаж, системийн шийдлийг зохион бүтээж, үйлдвэрлэдэг. Уул уурхай аж үйлдвэр, барилга угсралт, эрчим хүч, дэд бүтэц болон том оврын тоног төхөөрөмжийн холболтод өндөр хүчин чадалтай, найдвартай чангалгааны технологи шаардлагатай байдаг. Ийм хэрэглээнд мушгих моментыг тогтвортой, аюулгүй, өндөр нарийвчлалтайгаар дамжуулах нь процессын найдвартай ажиллагааны үндсэн нөхцөл болдог.

GEDORE-ийн их хүчний шийдлүүд нь:

- том оврын боолтны холболт
- үйлдвэрийн тоног төхөөрөмж
- шугам хоолойн систем
- хүнд машин механизм
- эрчим хүч ба дэд бүтцийн байгууламж зэрэг хэрэглээ багтана.

GEDORE-ийн мушгих моменты багажууд нь боолтыг найдвартай, өндөр нарийвчлалтай чангалах болон шаардлагатай үед гэмтээлгүй суллах боломжийг хангахаар инженерийн тооцоололтой бүтээгдсэн.



УР ЧАДВАРЫН НОТЛГОО

GEDORE-ийн уул уурхай, аж үйлдвэр, хүнд машин механизмд зориулсан загварууд нь гариг араат хүч дамжуулах системтэй. Энэ нь асаах, унтраах үед жигд, зөөлөн эргэлт үүсгэдэг найдвартай ажиллагаагаараа онцлогтой.



ИХ ХҮЧНИЙ МУШГИХ МОМЕНТ

ЗАГВАР	НМ	АШИГЛАХ ЗОРИУЛАЛТ	ДЭЛГЭЦ	ХҮЧДЭЛ	НЭМЭЛТ
GDA	60 250	УНИВЕРСАЛ	Аналог	Батарей	
GDA Solution	70 300	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	Баримтжуулалт
LDE-S/LEW-S	770 900	ХААЛТНЫ	Дижитал	Цахилгаан	
LDA-S Solution/ LAW-S Solution	500 1.200	ХААЛТНЫ	Дижитал	Батарей	Баримтжуулалт
LDA-S/LAW-S	500 1.200	ХААЛТНЫ	Аналог	Батарей	
LES	1.600 4.800	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	
LPS	3.000 4.800	УНИВЕРСАЛ	Дижитал	Хийн	
LDA/LAW	90 6.000	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	
LDA Solution/LAW Solution	90 6.000	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	Градус заалт, Баримтжуулалт
LHD	800 7.500	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	Градус заалт, Баримтжуулалт
LPK/LPK-X	80 12.800	УНИВЕРСАЛ	Аналог	Хийн	
LDE/LEW	90 13.000	УНИВЕРСАЛ	Дижитал	Цахилгаан	Градус заалт, Баримтжуулалт
LDK	160 24.000	УНИВЕРСАЛ		Гидраулик	
LDH	60 27.000	УНИВЕРСАЛ		Гидраулик	
LHU Гидраулик төхөөрөмж M, A, S		УНИВЕРСАЛ	Аналог (M, A) Дижитал (S)	Гидраулик	Баримтжуулалт (S)
Контортүлхүүр		УНИВЕРСАЛ			



ХҮЧ ӨСГӨГЧ

Загвар	Нм	Ашиглалт	шаталсан хэлбэртэй тулаас	шулуун хэлбэртэй тулаас	Буцалтын түгжээ	Сертификат
DVI-20Z (L) - DVI-28Z (L)	100 2.800	универсал				●
DVV-13Z (G) - DVV-40Z	50 4.000	универсал	стандарт	сонголт		●
DVV-40ZRS	500 4.000	универсал	стандарт	сонголт	●	●
DVV-60RS - DVV-80RS	650 8.000	универсал	стандарт	сонголт	●	●
DVV-100RS - DVV-130RS	1.000 13.000	универсал	стандарт		●	●
DVV-540RS	5.000 54.000	универсал	стандарт		●	



Мушгих моментын түлхүүр & Мушгих моментын халив


ЗАГВАР	Нм	НЭГЖ	АШИГЛАХ ЗОРИУЛАЛТ	ТӨРӨЛ	ДЭЛГЭЦ	НЭМЭЛТ
PRIME, PRO, TLS, QSN, QS, TT	0,04 13,5	cNm / Nm	Цуврал угсралт, Чанар шалгалт	Механик / Заалт	Аналог	EPA (Electronic Protected Area)
VDE 1.000 V	5 50	Nm	Универсал	Механик		VDE / 1.000 Volt
TSN, TSC	1 125	Nm / lbf.in	Цуврал угсралт	Механик		Сул эргэх үйлдэлтэй
ТТЗКН	10 350	Nm / lbf.in	Универсал	Заалт	Дижитал	Мушгих момент / Градус, Баримтжуулалт
TF-K, TF-SE, TF-Z	1 850	Nm / lbf.ft	Универсал	Механик		
DMK, DMUK, DMZ, DMSE	7 850	Nm / lbf.ft	Универсал	Механик		
ETQ, ETQR	0,25 1000	Nm / lbf.in	Чанар хяналт, Анализ	Механик	Дижитал	Олон төрлийн Анализ үйлдэл
TBN, Түр 88	0,4 1000	Nm / lbf.in	Цуврал угсралт	Механик		Нуграх үйлдэлтэй
ET25KA, ET2ZA	2 1000	Nm / lbf.in	Универсал + Чанар хяналт болон анализ	Заалт	Дижитал	Олон төрлийн хэмжих болон Анализ үйлдэл
Түр 83	0,8 2000	Nm / lbf.in / lbf.ft	Универсал + Чанар хяналт Анализ	Заалт	Аналог	Зүүн заалтын үйлдэл
DR, Нэг болон хоёр талын ажилгаатай, Z, SE, A+S, T-F5	2,5 3000	Nm / lbf.in / lbf.ft	Универсал, Цуврал угсралт	Механик		Уртын хамааралгүй / уртасгагчтай

Хүнд хүчир нөхцөлд шалгарсан DREMOMETER загвар 6 - 3000Нм



ТЕСТЕР

Загвар	Нм	Нэгж	Ашиглах зориулалт	Зориулалт	Хэмжих төрөл	Баримжуулалт
CAPTURE LITE	0,02 350	Nm / lbf.in / lbf.ft	Магадлан шалгалт Завсрын шалгалт	Моментын түлхүүр Моментын автирк	Track, 1. Peak, 2. Peak	●
CAPTURE HUB	0,1 1.500	cNm / Nm / ozf.in / lbf.in / lbf.ft	Магадлан шалгалт Завсрын шалгалт Сертификатын шалгалт	Моментын түлхүүр Моментын автирк Elektro-, Abschalt- und Impulsschrauber	Track, 1. Peak, 2. Peak	●
DREMOTEST-E	0,2 3.150	Nm / lbf.in / lbf.ft	Магадлан шалгалт Завсрын шалгалт	Моментын түлхүүр	1. Peak	●
E-TP (Elektronisches Torsions-Prüfgerät)	0,5 3.150	cNm / Nm / lbf.in / lbf.ft	Магадлан шалгалт Завсрын шалгалт Сертификатын шалгалт	Моментын түлхүүр Моментын автирк	Track, 1. Peak, 2. Peak	●



БООЛТ ХОЛБООСООС ЦААДАХ ИНЖЕНЕРИЙН ШИЙДЭЛ

Мушгих моменты багажийн аюулгүй ажиллагаа, урт хугацааны найдвартай ашиглалт нь зөвхөн худалдан авалтаас илүү өргөн ойлголт юм.

GEDORE үйлдвэрийн албан ёсны дистрибьютер ЧПМ ХХК нь багажийн нарийвчлал, хэмжилтийн тогтвортой байдал, процессын найдвартай ажиллагааг хангах зорилгоор туршилтын төхөөрөмж, тохируулга, баталгаажуулалт, сервис болон засвар үйлчилгээний иж бүрэн шийдлийг санал болгодог.

ЧПМ ХХК нь таны бүх төрлийн мушгих моменты багаж, төхөөрөмжийг DIN EN ISO 6789-2:2017, DAkkS, UKAS зэрэг стандартын шаардлагын дагуу шалгаж, тохируулж, баталгаажуулна.

Ингэснээр:

- үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа сайжрах
 - хэмжилтийн найдвартай байдал хангагдах
 - процессын эрсдэл буурах
 - ашиглалтын зардал хэмнэгдэх
- боломж бүрдэнэ.

Мөн манай мэргэжилтнүүд 0.04–54,000 Нм хүртэлх мушгих моменты хэрэглээнд зориулсан чангалгаа, сулралтын техникийн шийдэл болон инженерийн зөвлөгөөг мэргэжлийн түвшинд үзүүлдэг. ЧПМ ХХК нь зөвхөн бүтээгдэхүүн нийлүүлэхээс гадна мэдлэг, сургалт, инженерийн дэмжлэгээр дамжуулан урт хугацааны үнэ цэнийг хэрэглэгчдэд хүргэдэг.

ТОХИРУУЛГА • БАТАЛГААЖУУЛАЛТ • СЕРВИС

- Мушгих моменты багажийн тохируулга, баталгаажуулалт болон засвар үйлчилгээ
- GEDORE үйлдвэрийн болон DAkkS итгэмжлэлтэй баталгаажуулалтын үйлчилгээ
- GEDORE-ийн DAkkS итгэмжлэлтэй лабораторийн өндөр нарийвчлалтай хэмжилт
- UKAS итгэмжлэлтэй баталгаажуулалтын үйлчилгээ (BS 7882 стандартын дагуу)
- Аюулгүй ажиллагааг баталгаажуулах буцаж мөшгөх баримтжуулалт (Traceability documentation)

СУРГАЛТ • ЗӨВӨЛГӨӨ

- Бүтээгдэхүүний сонголт болон хэрэглээний зөвлөгөө
- Боолтны холболтын анализ, технологийн процессын оновчлол
- Чанарын хяналтын системийн интеграци
- Мушгих моменты технологийн мэргэшсэн сургалт
- Германы Боолтны Холбоо (Deutscher Schraubenverband)-той хамтарсан сургалтын хөтөлбөр
- Стандарт, техникийн шаардлагад нийцсэн тусгай сургалтууд

ЧПМ ХХК

Эрчим хүчний гудамж 9-1
16103 Улаанбаатар
Утас: 70104883
И-мэйл: info@bagaj.mn
Вэб: www.bagaj.mn